

ӨМЧ ХАМГААЛАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Д/д	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хэрэгжилт	Хувь
1	Өмч хамгаалах зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөө	Хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөтэй байна.	Өмч хамгаалах зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөөг 7 төрлийн ажил гүйцэтгэхээр төлөвлөж холбогдох дүрэм журам, байгууллагын зорилттой уялдуулан боловсруулж, зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу жилд хийх үндсэн болон нэмэлт ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж, холбогдох албан тушаалтнуудад үүрэг чиглэл өгч 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал тутам хянаж, биелэлтийг ханган ажилласан.	100%
2	2024 оны жилийн эцсийн тооллогын дүн холбогдох баримт бичигтэй танилцах	Хөрөнгийг санхүүгийн бүртгэлтэй тулгаж дутсан, актлах, данснаас хасах хөрөнгийн талаар шийдвэр гаргасан байна.	2024 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүн, тайлан, акт, бүртгэлийн баримт бичгүүдтэй бүрэн танилцаж, санхүүгийн бүртгэлтэй тулган нягталсан. Тооллогоор илэрсэн зөрчил, дутсан болон ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгийн талаар дүгнэлт гаргаж, актлах, данснаас хасах, хариуцлага тооцох асуудлыг холбогдох журмын дагуу шийдвэрлэсэн. Улмаар эд хөрөнгийн бүртгэл, хяналт сайжрах нөхцөл бүрдсэн.	100%
3	Өмч хамгаалах зөвлөлийн гаргасан шийдвэрийн биелэлттэй танилцах	Эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт сайжирсан байна.	Өмнө гаргасан шийдвэрүүдийн хэрэгжилтийг нэг бүрчлэн хянаж, биелэлтэд дүн шинжилгээ хийсэн. Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалттай холбоотой зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч, хариуцсан нэгж, ажилтнуудад чиглэл өгч ажилласан. Үүний үр дүнд эд хөрөнгийн эзэмшилт, хамгаалалтын байдал сайжирч, дахин зөрчил гарах эрсдэл буурсан.	95%
4	2025 оны эхний хагас жилийн тооллогын дүнг хэлэлцэх	Тооллоготой холбоотой шийдвэр гаргасан байна.	2025 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогын дүнг зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тооллогын явц, илэрсэн зөрчил, анхаарах асуудлын талаар нэгдсэн дүгнэлт гаргасан. Тооллогын дүнгээр 2025 оны хагас жилийн байдлаар 20,011 ширхэг 87,196,639,439 төгрөгийн үндсэн хөрөнгө, 25,653 ширхэг 958,652,181 төгрөгийн хангамжийн	100%

			<p>бараа материал болон 3,488,119,072 төгрөгийн үнэ бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл, 2671 ширхэг 556,734,245 төгрөгийн эмнэлгийн багаж хэрэгсэл тоологдсон. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 63 нэр төрлийн 1348 ширхэг 77,818,270 төгрөгийн хангамжийн материал болон 34 нэр төрлийн 68 ширхэг 13,573,259 төгрөгийн эмнэлгийн багаж хэрэгслийг акталж данснаас хассан.</li> <li>• Үлдэх өртөггүй 12 нэр төрлийн 263 ширхэг 62,847,240 төгрөгийн хөрөнгийг актлах саналыг ЭМЯ болон ТӨБЗГ-т хүргүүлсэн.</li> <li>• Ашиглах хугацаа дууссан ч ашиглах боломжтой 745 ширхэг 934,884,840 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээ хийлгэх албан бичгийг боловсруулан ТӨБЗГ-т илгээсэн.</li> <li>• 3 нэр төрлийн 2491 ширхэг 6,218,970 төгрөгийн өртөгтэй хугацаа дууссан мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эмүүдийг Цагдаагийн ерөнхий газрын хар тамхитай тэмцэх хэлтэст хүсэлт хүргүүлэн акталж, устгалд оруулах ажлыг зохион байгуулсан.</li> </ul>	
5	<p>Өмч хамгаалах зөвлөлийн гаргасан тооллогын шийдвэрлэх асуудал түвшинд байгааг хэрэгжилтийг анхаарах ямар явж хянаж,</p>	<p>Тооллоготой холбоотой гаргасан шийдвэрийн үр дүн гарсан байна.</p>	<p>Тооллогын дүнгээр гаргасан шийдвэрүүдийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, явцын мэдээллийг авч ажилласан. Шийдвэрийн хэрэгжилтийн хүрээнд эд хөрөнгийн бүртгэл шинэчлэгдэж, зөрчилтэй асуудлууд үе шаттайгаар шийдвэрлэгдсэн. Хэрэгжилтийн үр дүн бодитоор гарч, хяналтын тогтолцоо сайжирсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үлдэх өртөггүй 12 нэр төрлийн 263 ширхэг 62,847,240 төгрөгийн хөрөнгийг актлах саналыг ЭМЯ руу илгээж ЭМЯ ТӨБЗГ-т хүргүүлсэн боловч ТӨБЗГ-аас хариу албан мэдэгдэл ирээгүй байна.</li> <li>• Ашиглах хугацаа дууссан ч ашиглах боломжтой 745 ширхэг 934,884,840 төгрөгийн хөрөнгийг 467,442,420.00 дахин үнэлгээ хийлгэх албан бичгийг боловсруулан ТӨБЗГ-т илгээсэн ба ТӨБЗГ-аас зөвшөөрсөн хариу албан тоот ирсэн тул дахин үнэлгээг программд оруулж баталгаажуулалт хийсэн.</li> </ul>	100%

6	Өмч хамгаалах зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж Удирдлагын зөвлөлд танилцуулах	ӨХЗ-ийн ажил тайлан Удирдлагын зөвлөлөөр баталгаажсан байна.	<p>2025 онд хагас жил болон жилийн эцсийн тооллого гэж 2 удаа эмнэлгийн үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгө хангамжийн материал болон эм, эмнэлгийн хэрэгслийг тоолон баталгаажуулалт хийсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 20,434 ширхэг 87,756,120,223 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнээс 20,434 ширхэг 87,756,120,223 төгрөгийн өртөг бүхий үндсэн хөрөнгө тоологдсон. Түр гадагш ашиглуулах гэрээгээр шилжүүлсэн 22 ширхэг 1,521,282,890 төгрөгийн хөрөнгө тоологдоогүй. 2025 онд худалдан авсан, Эрүүл мэндийн сайдын тушаалаар орлогод авсан, хандиваар орлогод авсан бүгд 50 нэр төрлийн 480 ширхэг 2,038,674,191 төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.</li> <li>• Зөөлөн эдлэл 4,192 ширхэг 235,913,348 төгрөг, бичиг хэргийн материал 676 ширхэг 56,111,472 төгрөг, бусад хангамжийн материал 6,857 ширхэг 570,870,364 төгрөгийн нийт 11,725 ширхэг 862,895,185 төгрөгийн эргэлтийн хөрөнгийн баталгаажуулалт хийгдсэн.</li> <li>• 1,826 ширхэг 631,122,443.38 төгрөгийн эмнэлгийн багаж хэрэгсэл, 3,921,060,286.06 төгрөгийн үнэ бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл бүртгэлтэй байна.</li> </ul>	100%
7	Бусад асуудал	Хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн байна.	<p>Жилийн явцад үүссэн бусад асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн хэлэлцэж, тухай бүр шийдвэрлэсэн. Өмчтэй холбоотой эрсдэл, зөрчлийг бууруулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан.</p> <p>Өмч эзэмшүүлэх гэрээг ТӨБЗГ-т очин дүгнүүлж хангалттай үнэлгээ авч гэрээг сунган ажилласан.</p>	100%

ХЯНАСАН: ӨМЧ ХАМГААЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН ЭДИЙН ЗАСАГЧ

*Н. Баасан*

/Ц.ТУЛГА/

/Н.БААСАН/